

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.22 № 06/208  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Тамгын газрын дарга Ц.Арвинбуудай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Сэржмядаг, Г.Мөнхчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2/378 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Прокурорын байгууллагын үйл ажиллагааг нэгдмэл төвлөрсөн удирдлагаар хангах үүднээс хүний нөөц, захиргаа, дотоод ажил, төсөв, санхүү, аж ахуй, хууль тогтоомжид заасан хангалт, үйлчилгээ, төрийн албан хэрэг хөтлөлт, хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал, прокурор, ажилтны нийгмийн асуудлын талаар бодлого боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцож ажиллана.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан.

Төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын прокурорын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Acolous програм хангамж ашигладаг байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлын хувиар сонгов.

Үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тайлант онд төсвөөс авсан урсгал санхүүжилтийн зарцуулалт болон бусад үйл ажиллагааг бүрэн хамруулах горим сорил хэрэгжүүлэхтэй холбоотой юм.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,330,151.9 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 63,301.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөг/				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	6,450.6	
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>6,450.6</b>	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,453,150.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,446,699.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,450.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлээ.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Хан-Уул дүүрэгт байрлах бараа материал дансанд бүртгэлтэй 2,405,875.3 мянган төгрөгийн дуусаагүй барилгын 000439335 улсын бүртгэлийн дугаартай 44,818 м<sup>2</sup> газрыг бүртгээгүй байна. Дахин үнэлгээний аргачлалаар үнэлэхэд 461,625.4 мянган төгрөгийн бодит үнэ цэнтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Хан-Уул дүүрэгт байрлах бараа материал дансанд бүртгэлтэй 2,405,875.3 мянган төгрөгийн дуусаагүй барилгын 44,818 м<sup>2</sup> газрыг Сангийн сайдын 207 дугаар тушаалаар



батлагдсан аргачлалын дагуу 461,625.4 мянган төгрөгийн бодит үнэ цэнтэй гэж үнэлэн санхүүгийн тайланг залруулж бүртгэв.

2. Санхүүгийн байдлын тайлангийн засгийн газрын хувь оролцооны эхний болон эцсийн үлдэгдэл Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн Засгийн газрын хувь оролцооны дүнгийн эхний болон эцсийн үлдэгдэлтэй 88,200.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан маягтаар бэлтгээгүй, хөтөлбөр зориулалт болон төсвийн хэлбэлзлийн тайлан, тохируулгын тайлан гаргаагүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Сангийн сайдын 2013 оны 76 дугаар тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

4. Дахин үнэлгээтэй холбоотойгоор үндсэн хөрөнгийн тодруулга тайланд туссан өөрчлөлтүүд санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан болон ерөнхий дэвтэр, ерөнхий журналтай зөрүүтэй байгаагаас биет хөрөнгө 896,874.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын дараагийн тайлангийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татах чухал асуудал гараагүй болно.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 5,441,738.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газар урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн зардалд улсын төсвөөс 5,441,738.9 мянган төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 5,440,735.6 мянган төгрөгийг зарцуулж 1,003.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 99.9 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газар нь улсын төсөвт үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Балансын данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Бараа материал дансанд 351 толгой хонь, хургыг нэг бүрийг 6.0-23.0 мянган төгрөгөөр нийт 4,468.0 мянган төгрөгөөр бүртгэсэн нь УСНББОУС-12 "Бараа материал"-ын 15 дугаар зүйл Бараа материалыг 16 эсвэл 17 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд өртөг ба цэвэр боломжит үнэ цээнийн аль багаар үнэлнэ гэж заасантай нийцэхгүй байна.

Энэ нь үнэн зөв, бодитой оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС-12 тус тус зөрчсөн байна.

##### **1.2. Эрсдэл:**

Байгууллагын эзэмшилд байгаа мал, амьтадыг бодит үнэ цэнээр бүртгээгүй байх

##### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Бараа материал дансанд бүртгэлтэй 351 толгой хонь, хурга /нэг бүр нь 6.0-23.0 мянган төгрөг/ нийт 4,468.0 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлэн бүртгэх

##### **1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

#### **2. Балансын данстай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

Санхүүгийн тайланд 21.4 мянган төгрөгийн эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актгүй өглөг бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй, бүртгэлээр тавих хяналт сул байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актгүй 21.4 мянган төгрөгийн өглөгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актгүй 76.9 мянган төгрөгийн авлага, өмнөх оноос шилжиж ирсэн 1,731.2 мянган төгрөгийн томилолтын урьдчилгааны үлдэгдэл тооцоо нийлж буцаан төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй, бүртгэлээр тавих хяналт сул байх

3.3. Өгсөн зөвлөмж:

Тооцоо нийлсэн актгүй 76.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулах, өмнөх оноос шилжиж ирсэн томилолтын урьдчилгаа 1,731.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх

3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,609,957,928.95</u></b>	<b><u>2,824,161,457.82</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	31,289,612.74	3,909,071.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	23,014,012.74	3,126,311.55
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	126,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	8,149,600.00	782,760.00
3351	Байгууллагаас авах авлага	8,149,600.00	782,760.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	1,654,300.00	1,654,300.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	1,654,300.00	1,654,300.00
34714	Томилолтын урьдчилгаа	1,654,300.00	1,654,300.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	2,577,014,016.21	2,818,598,086.27
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	2,405,875,372.00	2,405,875,372.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	50,750,060.00	225,659,960.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	115,476,584.21	182,364,754.27
35410	Бичиг хэргийн материал	7,789,834.50	6,685,950.00
35420	Аж ахуйн материал	87,917,029.71	100,994,474.27
35430	Сэлбэг хэрэгсэл	1,115,000.00	1,441,000.00
35470	Бусад хангамжийн материал	18,654,720.00	73,243,330.00
35600	Мал амьтад	4,912,000.00	4,698,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,288,925,478.52</u></b>	<b><u>6,112,540,874.24</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,288,925,478.52	6,112,540,874.24
391	Газар	-	-
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,288,694,478.38	5,431,399,214.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,055,041,252.55	3,503,248,560.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,396,967,599.24)	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,473,570,142.80	1,917,581,331.94
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,308,525,906.20)	(1,279,774,222.07)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	874,013,988.91	1,770,854,315.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	(757,556,971.84)	(792,600,327.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	487,880,362.60	494,242,113.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(215,992,037.34)	(257,437,351.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	97,560,061.70	102,179,471.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	(29,573,597.56)	(36,139,459.87)
39217	Ном	9,244,782.00	9,244,782.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	231,000.14	681,141,660.18
39301	Програм хангамж	157,075,171.94	157,075,171.94
39302	Хуримтлагдсан элэгдэл	(156,844,171.80)	(156,998,171.76)

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39303	Бусад биет бус хөрөнгө	2,910,000.00	683,974,660.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,910,000.00)	(2,910,000.00)
<b>394</b>	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>7,898,883,407.47</u></b>	<b><u>8,936,702,332.06</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>25,259,361.86</u></b>	<b><u>260,876,541.60</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	25,259,361.86	29,661,635.40
<b>413</b>	<b>Өглөг</b>	25,259,361.86	29,661,635.40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	913,500.00
41350	Зээлийн хүүгийн өглөг	-	2,132,682.96
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	25,259,361.86	26,615,452.44
41361	Байгууллагад төлөх өглөг	25,259,361.86	26,615,452.44
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	-	-
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	231,214,906.20
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	-	231,214,906.20
<b>4222</b>	<b>Гадаад валют</b>	-	231,214,906.20
42223	Санхүүгийн зээл	-	231,214,906.20
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,873,624,045.61</u></b>	<b><u>8,675,825,790.46</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	7,873,624,045.61	8,675,825,790.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,872,986,772.99	4,554,051,432.99
51101	Өмч: - төрийн	3,872,986,772.99	4,554,051,432.99
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,257,935,724.82	3,468,030,465.41
51210	Өмнөх үеийн үр дүн	874,482,268.50	3,257,935,724.82
51220	Тайлант үеийн үр дүн	2,383,453,456.32	210,094,740.59
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	742,701,547.80	653,743,892.06
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>7,898,883,407.47</u></b>	<b><u>8,936,702,332.06</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>7,526,688,219.80</b>	<b>6,540,246,710.45</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>-</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,515,793,649.80</b>	<b>1,089,886,735.14</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,515,793,649.80	1,089,886,735.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,515,793,649.80	1,088,221,329.14
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,515,793,649.80	1,088,221,329.14
120009	Бусад орлого	00.00	1,665,406.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,010,894,570.00</b>	<b>5,450,359,975.31</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,002,947,000.00	5,441,738,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,002,947,000.00	5,441,738,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,947,570.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,947,570.00	6,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00.00	2,621,075.31
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	2,621,075.31
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,119,274,713.37</b>	<b>5,222,330,409.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,119,274,713.37</b>	<b>5,222,330,409.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5,007,996,915.63	5,025,223,663.64
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	3,273,014,438.33	3,343,995,181.81
210101	Үндсэн цалин	3,188,459,838.33	3,343,995,181.81
210102	Нэмэгдэл	00.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,554,600.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	362,680,801.29	398,881,685.43
210201	Тэтгэврийн даатгал	362,680,801.29	398,881,685.43
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	93,707,588.31	96,878,515.20
210301	Гэрэл, цахилгаан	41,401,256.60	47,714,177.00
210302	Түлш, халаалт	30,325,531.35	42,731,371.20
210303	Цэвэр, бохир ус	13,206,787.50	6,432,967.00
210304	Байрны түрээс	8,774,012.86	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	432,998,623.33	438,505,428.42
210401	Бичиг хэрэг	24,374,791.00	26,330,449.50
210402	Тээвэр, шатахуун	66,238,938.10	85,937,207.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	270,891,147.44	251,540,911.78
210404	Ном, хэвлэл	1,290,000.00	3,251,060.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,965,000.00	1,509,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	61,661,346.79	68,804,799.44

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	6,577,400.00	1,132,000.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	419,400.00	18,672,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	419,400.00	18,672,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	335,952,829.00	204,500,822.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	3,918,730.00
210604	Урсгал засвар	335,952,829.00	200,582,092.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	50,004,523.00	97,948,527.00
210701	Гадаад албан томилолт	13,151,750.00	58,889,105.00
210702	Дотоод албан томилолт	15,528,615.00	28,071,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	21,324,158.00	10,988,222.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	57,847,930.00	74,471,999.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00	12,325,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	25,048,410.00	32,702,619.11
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,604,720.00	2,941,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	713,800.00	737,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,200,800.00	24,451,300.00
210807	Газрын төлбөр	4,280,200.00	1,314,380.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	401,370,782.37	351,369,454.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,347,100.00	11,374,255.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	71,605,968.00	91,404,022.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	328,417,714.37	248,591,177.13
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	111,277,797.74	197,106,745.67
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	104,204,800.00	195,354,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,024,800.00	162,679,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,180,000.00	32,675,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,072,997.74	1,723,878.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,072,997.74	1,723,878.67
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	28,567.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	28,567.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>-</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>2,407,413,506.43</u></b>	<b><u>1,317,916,301.14</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	00.00	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	23,960,050.11	1,107,821,560.55
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	23,960,050.11	123,129,202.99
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	516,000.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	984,176,357.56
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(23,960,050.11)	(1,107,821,560.55)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>2,383,453,456.32</u></b>	<b><u>210,094,740.59</u></b>



### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>5,010,894,570.00</u></b>	<b><u>5,455,432,630.00</u></b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>7,693,730.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0.00	7,693,730.00
120009	Бусад орлого	0.00	7,693,730.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,010,894,570.00</b>	<b>5,447,738,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,002,947,000.00	5,441,738,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,002,947,000.00	5,441,738,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,947,570.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,947,570.00	6,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>4,985,849,407.00</u></b>	<b><u>5,189,699,941.48</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,985,849,407.00</b>	<b>5,189,699,941.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,850,721,609.26</b>	<b>4,980,558,129.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	3,286,008,669.70	3,309,794,520.74
210101	Үндсэн цалин	3,201,454,069.70	2,188,866,020.74
210102	Нэмэгдэл	0.00	910,577,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,554,600.00	138,037,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	72,313,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	344,002,606.00	399,648,300.00
210201	Тэтгэврийн даатгал	344,002,606.00	267,735,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	32,978,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	26,382,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	6,595,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	65,956,500.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	95,751,831.96	99,206,481.00
210301	Гэрэл, цахилгаан	43,945,716.60	44,628,904.00
210302	Түлш, халаалт	32,369,775.00	47,849,128.00
210303	Цэвэр, бохир ус	10,662,327.50	6,728,449.00
210304	Байрны түрээс	8,774,012.86	0.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	497,518,983.60	443,814,796.48
210401	Бичиг хэрэг	24,619,671.00	25,354,149.00
210402	Тээвэр, шатахуун	63,636,938.10	85,937,207.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	328,124,250.50	251,387,673.78
210404	Ном, хэвлэл	2,077,900.00	3,397,760.00

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,965,000.00	1,509,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	77,095,224.00	76,229,006.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>4,779,400.00</b>	<b>205,045,850.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,779,400.00	205,045,850.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>414,791,239.00</b>	<b>209,620,922.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,072,660.00	3,716,130.00
210604	Урсгал засвар	413,718,579.00	205,904,792.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>67,815,000.00</b>	<b>98,134,727.00</b>
210701	Гадаад албан томилолт	30,598,050.00	58,802,994.00
210702	Дотоод албан томилолт	15,528,615.00	27,803,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	21,688,335.00	11,528,533.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>57,847,930.00</b>	<b>117,113,499.11</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00	55,635,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	25,048,410.00	32,702,619.11
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,604,720.00	2,941,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	713,800.00	737,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,200,800.00	23,782,500.00
210807	Газрын төлбөр	4,280,200.00	1,314,380.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>82,205,949.00</b>	<b>98,179,033.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,999,900.00	6,727,811.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	77,206,049.00	91,451,222.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>135,127,797.74</b>	<b>209,141,811.67</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>128,054,800.00</b>	<b>207,389,366.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,704,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,024,800.00	162,679,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,326,000.00	44,710,066.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,072,997.74</b>	<b>1,723,878.67</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,072,997.74	1,723,878.67
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>28,567.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	28,567.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>25,045,163.00</u></b>	<b><u>265,732,688.52</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>29,164,060.00</b>	<b>265,732,688.52</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,164,060.00</b>	<b>265,732,688.52</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>29,164,060.00</b>	<b>265,732,688.52</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,164,060.00	265,732,688.52
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(29,164,060.00)</u></b>	<b><u>(265,732,688.52)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
14	Бусад эх үүсвэр	0.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.00	0.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	0.00	0.00
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(4,118,897.00)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,118,897.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2016 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл</b>	3,872,986,772.99	742,701,547.80	843,455,858.56	5,459,144,179.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	31,026,409.94	31,026,409.94
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,872,986,772.99</b>	<b>742,701,547.80</b>	<b>874,482,268.50</b>	<b>5,490,170,589.29</b>
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,383,453,456.32	2,383,453,456.32
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл</b>	<b>3,872,986,772.99</b>	<b>742,701,547.80</b>	<b>3,257,935,724.82</b>	<b>7,873,624,045.61</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,872,986,772.99</b>	<b>742,701,547.80</b>	<b>3,257,935,724.82</b>	<b>7,873,624,045.61</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	(88,957,655.74)	0.00	(88,957,655.74)
D08	Тайлант үеийн үр дүн	681,064,660.00	0.00	210,094,740.59	891,159,400.59
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,554,051,432.99</b>	<b>653,743,892.06</b>	<b>3,468,030,465.41</b>	<b>8,675,825,790.46</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг /					
Код	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,441,738,900.00</b>	<b>5,440,735,621.33</b>	<b>1,003,278.67</b>	<b>100.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,441,738,900.00</b>	<b>5,440,735,621.33</b>	<b>1,003,278.67</b>	<b>100.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,240,819,600.00</b>	<b>5,239,817,688.33</b>	<b>1,001,911.67</b>	<b>100.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,310,105,100.00</b>	<b>3,309,794,520.74</b>	<b>310,579.26</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	2,189,176,600.00	2,188,866,020.74	310,579.26	100.0
210102	Нэмэгдэл	910,577,200.00	910,577,200.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	138,037,800.00	138,037,800.00	-	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	72,313,500.00	72,313,500.00	-	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>399,648,300.00</b>	<b>399,648,300.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	267,735,300.00	267,735,300.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	32,978,300.00	32,978,300.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,382,400.00	26,382,400.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	6,595,800.00	6,595,800.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	65,956,500.00	65,956,500.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>99,208,000.00</b>	<b>99,206,481.00</b>	<b>1,519.00</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	44,629,000.00	44,628,904.00	96.00	100.0
210302	Түлш, халаалт	47,850,000.00	47,849,128.00	872.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	6,729,000.00	6,728,449.00	551.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>442,644,900.00</b>	<b>442,571,796.48</b>	<b>73,103.52</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	16,758,000.00	24,951,149.00	(8,193,149.00)	148.9
210402	Тээвэр, шатахуун	71,842,000.00	85,937,207.70	(14,095,207.70)	119.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	274,188,000.00	251,387,673.78	22,800,326.22	91.7
210404	Ном хэвлэл	2,600,000.00	2,557,760.00	42,240.00	98.4
210405	Хог хаягдал залуулах, хортон мэргэчдийн утгал, ариутгал	1,900,000.00	1,509,000.00	391,000.00	79.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	75,356,900.00	76,229,006.00	(872,106.00)	101.2
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>205,143,300.00</b>	<b>205,045,850.00</b>	<b>97,450.00</b>	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	205,143,300.00	205,045,850.00	97,450.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>406,053,700.00</b>	<b>406,047,492.00</b>	<b>6,208.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	183,002,700.00	170,152,700.00	12,850,000.00	93.0
210602	Тавилга	29,990,000.00	29,990,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	193,061,000.00	205,904,792.00	(12,843,792.00)	106.7
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>98,514,500.00</b>	<b>98,134,727.00</b>	<b>379,773.00</b>	<b>99.6</b>
210701	Гадаад томилолт	43,303,400.00	58,802,994.00	(15,499,594.00)	135.8
210702	Дотоод албан томилолт	43,880,400.00	27,803,200.00	16,077,200.00	63.4
210703	Зочин төлөөлөгч хүлэн авах	11,330,700.00	11,528,533.00	(197,833.00)	101.7
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>154,824,100.00</b>	<b>154,696,599.11</b>	<b>127,500.89</b>	<b>99.9</b>

Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	93,344,400.00	93,218,400.00	126,000.00	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	32,702,700.00	32,702,619.11	80.89	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,941,700.00	2,941,700.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	737,000.00	737,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,782,500.00	23,782,500.00	-	100.0
210807	Газрын төлбөр	1,315,800.00	1,314,380.00	1,420.00	99.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>124,677,700.00</b>	<b>124,671,922.00</b>	<b>5,778.00</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,220,700.00	33,220,700.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	91,457,000.00	91,451,222.00	5,778.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>200,919,300.00</b>	<b>200,917,933.00</b>	<b>1,367.00</b>	<b>100.0</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,919,300.00	200,917,933.00	1,367.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	162,679,300.00	162,679,300.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	38,240,000.00	38,238,633.00	1,367.00	100.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,441,738,900.00</b>	<b>5,440,735,621.33</b>	<b>1,003,278.67</b>	<b>99.9</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>5,441,738,900.00</b>	<b>5,440,735,621.33</b>	<b>1,003,278.67</b>	<b>99.9</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,441,738,900.00	5,440,735,621.33	1,003,278.67	99.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	154	154	-	100.0
620001	Удирдах ажилтан	11	11	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	83	83	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	60	60	-	100.0

Хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газар			САГ-2019/284/СТА-ТШЗ
				Мянган төгрөг

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Бараа материал дансанд 351 толгой хонь, хургыг нэг бүрийг 6.0-23.0 мянган төгрөгөөр нийт 4,468.0 мянган төгрөгөөр бүртгэсэн	4,468.0	Зөвлөмж	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Ц.Арвинбуудай С.Нямцэвээн
Санхүүгийн тайланд 21.4 мянган төгрөгийн эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актгүй өглөг бүртгэлтэй байна.	21.4	Зөвлөмж		
Эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актгүй 76.9 мянган төгрөгийн авлага, өмнөх оноос шилжиж ирсэн 1,731.2 мянган төгрөгийн томилолтын урьдчилгааны үлдэгдэл тооцоо нийлж буцаан төвлөрүүлээгүй байна.	1,731.2	Зөвлөмж		
<b>Зөвлөмжийн дүн</b>	<b>6,450.6</b>			